

МОНГОЛ ОРНЫ ГЕОЛОГИ, АШИГТ МАЛТМАЛЫН ЭРЭЛ ХАЙГУУЛЫН АЖЛЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

М.ТОДБИЛЭГ

Уул уурхайн яам
Геологийн бодлогын хэлтэс

Геологийн мэргэжлийн ихэнх хүмүүс геологийг маш олон салбартай холбогддог, хамааралтай гэдгийг мэддэг энгийн ойлголт мэт боловч манайд геологийг зөвхөн ашигт малтмал, уурхайтай холбож ойлгох, ярих байдал давамгайлсан байна. Энэ нь ч аргагүй өнөөдрийн ашигт малтмал, уул уурхайн эдийн засгийн их давалгаатай холбоотой юм. Чухамхүү ийм цаг үед геологич бид өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж ойлголт, санаагаа илэрхийлж байна.

Монгол орны геологи, хайгуулын салбарт сүүлийн 12 жилд оруулсан хөрөнгө оруулалтыг зөвхөн уул уурхайн хөрөнгө оруулалт ба бүтээгдэхүүний нийт дүнтэй харьцуулж үзэхэд нийт дүнгийн 1.74-19.28%-ийг эзэлж байна. Энэ хувь нь 2011 оны байдлаар 6.1%-тай байгаагаас үзэхэд хэрвээ бусад салбаруудыг нийтэд нь хамруулан авч үзвэл геологийн судалгаанд ногдох хувь маш бага хэмжээтэй гарахаар байна. Үүнээс үзвэл, Монгол орны геологийн судалгааг тодорхой бодлого, төлөвлөгөөтэйгээр хөгжүүлэх, нэгтгэн зохион байгуулах шаардлага буй нь харагдаж байна.

Түлхүүр үг: Геологи, ашигт малтмалын хайгуул, уурхай

1. Геологи

Геологи нь шинжлэх ухааны болон аж үйлдвэрийн олон салбарын уулзвар, төвлөрөл нь юм. Геологи нь геофизик, геохими, минералог, петрологи, геостатистик, гидрогеологи, палеонтолог, тектоник, геодинамик, инженер геологи, гео-мэдээлэл, геохронолог, гео-экологи, геотехник гэх мэт олон салбаруудаар физик, хими, математик, статистик, гидрологи, биологи, астрологи, газар хөдлөл, динамик, мэдээлэл зүй, хронологи, экологи зэрэг суурь ухааны олон салбаруудтай, мөн цаашилбал уул уурхай, эрчим хүч, хүнд үйлдвэр, зам, барилга, хөдөө аж ахуй, газрын харилцаа, металлурги, химийн үйлдвэрлэл зэрэг аж үйлдвэрийн салбаруудтай холбогддог (зураг 1). Ихэнх хүмүүс үүнийг мэддэг, энгийн ойлголт мэт боловч сүүлийн үед геологийг зөвхөн ашигт малтмал, уул уурхайтай холбож ойлгох, ярих байдал нийгэмд давамгайлсан байна. Энэ нь ч аргагүй өнөөдрийн ашигт малтмал, уул уурхайн эдийн засгийн их давалгаатай холбоотой юм. Чухамхүү ийм цаг үед геологич бид өөрснөө ойлголт, санаагаа илэрхийлж байна. Жишээ нь, геологич Н.Батбаяр, Б.Батром нар 1:50000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлаар ашигт

малтмалын эрдэсжсэн цэг, илрэл илрүүлэх, мэдээлэл болон мэргэжилтэн бэлтгэх зэрэг чухал ач холбогдолтойг болон тухайн ажлын зарим бэрхшээлийг дурьдаж, “Геологи бол үйлдвэрлэлийг төрүүлэгч пионер мөн” гэсэн нэгэн нэрт хүний үгийг ишлэсэн¹ нь бас анхааруштай юм. Мөн зөвлөх геологич Д.Эрдэнэ хайлуур жоншны хайгуул хийж, нөөцөө өсгөхгүй бол тогтоосон нөөцөө олборлон дуусч тухайн үйлдвэрлэл зогсохоор түүн дээр суурилсан зарим хот суурин хүнд байдалд орж буй талаар сануулсан өгүүлэл нийтлүүлжээ². Мөн Д.Амаржаргал, Н.Баатар, Б.Энхтуяа, Д.Мөнх гээд олон хүмүүс Геологи уул уурхайн мэдээ сонины 2012 оны дугааруудад геологийн салбарын талаар өөрсдийн байр суурь, саналаа илэрхийлсэн байна^{4,5,6,7}.



Зураг 1. Геологи, түүний салбарууд ба суурь ухаан (товчлон харуулав)

Ингэж үзэхээр геологи нь нэлээд суурь “шинжлэх ухаан – аж үйлдвэр”-ийн салбар болох нь тодорхой тул улс орны бодлого, хөтөлбөр, бүх төрлийн ажлууд энэ суурь үндэстэйгээ уялдсан, эргэх холбоотой байх нь оновчтой.

Геологийн судалгааг явуулгааг явуулж түүний үндсэн дээр ашигт малтмалын орд нээхэд геологичид болон бусад олон төрлийн мэргэжлийн хүмүүсийн хамтарсан багууд олон жил ерөнхийгээс нарийн хүртэл хийсэн асар их ажлуудын үр дүн болон тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт шаардагддаг.

Өнөөдөр манай улсад энэ суурь судалгаа буюу геологийн судалгаа хэрэгтэй юу гэвэл маш их хэрэгтэй буюу түрүүлж явах учиртай. Суурь нь бат бэх бол аливаа зүйл удаан оршин тогтдогтой адил зүйл юм ³.


2. Геологи, хайгуулын ажлын хөрөнгө оруулалт

Монгол орны геологи, хайгуулын ажилд сүүлийн 12 жилд оруулсан хөрөнгө оруулалтыг уул уурхайн хөрөнгө оруулалт ба бүтээгдэхүүний дүнтэй харьцуулан авч үзэхэд нийт дүнгийн 1.74-19.28%-ийг эзэлж байна (хүснэгт 1; зураг 2, 3).


Монгол орны ашигт малтмалын хайгуулын хөрөнгө оруулалт ба түүний үр дүн, тэрбум төгрөг

Хүснэгт-1

Хөрөнгө оруулалт, үр дүн	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011
Хайгуулын хөрөнгө оруулалт	6.02	5.23	15.52	40.5	62.6	100.7	198	280.24	168.8	146.3	182.7	332
Уул уурхайн хөрөнгө оруулалт	21.6	49.92	39.84	39.6	63.6	98.4	151.2	524.4	603.6	901.2	1345.2	2038.8
Уул уурхайн бүтээгдэхүүн	318	324	392	378	635	791	678	1269	1583	1496	2633	3061.4
Нийт, тэрбум төгрөг	345.6	379.1	447.3	458.1	761.2	990	1027	2073.6	2355.4	2543.5	4160.9	5282.9
Нийт дүнд хайгуулын хөрөнгө оруулалтын эзлэх хувь, %	1.74	1.38	3.47	8.84	8.22	10.17	19.28	13.51	7.17	5.75	4.39	6.11



Зураг 2. Монгол орны ашигт малтмалын хайгуулын хөрөнгө оруулалт ба түүний үр дүн, тэрбум төгрөг.



Зураг 3. Монгол орны ашигт малтмалын хайгуулын хөрөнгө оруулалт, тэрбум төгрөг (а), хайгуул болон уурхайн хөрөнгө оруулалт, бүтээгдэхүүний нийт дүнд хайгуулын хөрөнгө оруулалтын эзлэх хувь, % (б).

Ашигт малтмалын хайгуулын хөрөнгө оруулалтыг дангаар нь (зураг 2а) авч үзэхэд 1999 оноос хойш ерөнхийдөө өсөлттэй бөгөөд 2007 оноос буураад, эргээд өссөн дүнтэй харагдах боловч түүнийг уул уурхайн хөрөнгө оруулалт, бүтээгдэхүүний нийт дүнтэй харьцуулахад 2007 оноос хойш огцом буурч 2010 онд 2002 оны түвшиндээ хүрээд, 2011 онд эргэн нэлээд өсч 332 тэрбум төгрөгт хүрсэн байна. Энэ нь мэдээж уул уурхайн хөрөнгө оруулалт, бүтээгдэхүүний өсөлттэй шууд хамааралтай боловч геологи, хайгуулын хөрөнгө оруулалтанд анхаарч байх зохих хувь хэмжээг илэрхийлээд байх шиг. Энэхүү хувь хэмжээ нь 10% байх нь оновчтой харагдаж байна.

Геологийн судалгаанд оруулж буй хөрөнгө оруулалтыг зөвхөн уул уурхайн салбартай харьцуулахад 2011 оны байдлаар 6.1%-тай байгаагаас үзэхэд хэрвээ бусад салбаруудыг нийтэд нь оруулан авч үзвэл геологийн судалгааны эзлэх хэмжээ маш бага хувьтай гарахаар байна. Эндээс Монгол орны геологийн нийт судалгааг нэгдсэн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөтэйгээр хөгжүүлэх, нэгтгэн зохион байгуулах шаардлага буй нь харагдаж байна. Энд зөвхөн ашигт малтмал, уурхайн асуудал төдийгүй өөр бусад олон салбаруудыг өргөн хүрээтэй хамруулан авч үзэн, тэдний зохистой уялдаа холбоо болон геологийн судалгааны тогтвортой хөгжлийг хангах нь зүйтэй юм.

Өнөөдрийн байдлаар геологийн салбарын асуудал дараах байдлаар төрийн байгууллагуудад хуваарилагдсан байна. Үүнд:

- Геологи, эрдэс баялгийн асуудал Уул уурхайн яаманд,
- Геологи, ашигт малтмалын хэрэгжилтийн асуудал Ашигт малтмалын газарт,
- Газрын тосны асуудал Газрын тосны газарт;
- Цацраг идэвхт ашигт малтмал Цөмийн энергийн газарт;
- Гидрогеологи, геоэкологи, усны асуудал Байгаль орчин, ногоон хөгжлийн яам;
- Инженер геологийн асуудал Барилга, хот байгуулалтын яаманд;

- Геологийн эрдэм шинжилгээ, сургалт Боловсрол, шинжлэх ухааны яам, хүрээлэн, их сургуулиудад.
- Улсын геологийн судалгааны байгууллага, лаборатори, компани нь Төрийн өмчийн хорооны харьяанд гэх мэт.

3. Дүгнэлт

Геологи нь дээрхи байдлаар олон газарт харьяалагдан тархсан нь хоорондоо мэдээлэл солилцоо, нэгтгэл хангалттай биш байгаа бөгөөд геологийн шинжлэх ухааны суурь төвлөрсөн шинж чанартай (зураг 1) уялдуулан тэдгээрийг холбох, нэгтгэх хэрэгтэй юм.

Геологичдын сонин хэвлэлээр илэрхийлсэн саналуудыг нэгтгэн дүгнэвэл дараах саналууд нэлээд зонхилон тавигдаж байна. Үүнд:

- Геологийн судалгаа, хайгуулын ажлын мэдээллээ төр бүрэн гүйцэт хүлээн авдаг байхад анхаарах,
- Геологийн салбарыг төрөөс нэгтгэн зохион байгуулж, улсын төсвийн хөрөнгөөр ашигт малтмалын хайгуулын ажил хийж, томоохон орд газруудыг эдийн засгийн эргэлтэнд оруулах ажилд дорвитой түлхэц болох.

Цаашид геологийн салбарын талаархи саналуудыг үргэлжлүүлэн нэгтгэн боловсруулж, дүн шинжилгээ хийх тул та бүхэн саналаа илэрхийлж байхыг хүсье.

Ашигласан материал

1. **Батбаяр Н., Батром Б., 2012,** 1:50000-ны зураглалын ажлаа түлхүү хийцгээе. Хайгуулчин, дугаар 46, ху. 299.
2. **Эрдэнэ Д., 2012,** Монголын хайлуур жоншны судалгаа ба нөөцийн төлөв байдал. Хайгуулчин, дугаар 46, ху. 300-302.
3. **Тодбилэг М., 2009,** Монгол орны хөгжилд геологи, хайгуулын судалгаа хэрэгтэй юу? /чөлөөт хэлэлцүүлэг/. Монголын Геосудлаач, Монголын геологийн албаны 70 жилийн ойд зориулсан тусгай дугаар 34, ху. 215-217.
4. **Баатар Н.** Хүсч сонирхсон мэргэжил минь Монгол орны хөгжил дэвшилд тустай. “Геологи уул уурхайн мэдээ” сонин, 2012 оны 8-р сар, №22 (94).
5. **Мөнх Д.** Монголын геологийн судалгааны тулгамдсан асуудлууд. “Геологи уул уурхайн мэдээ” сонин, 2012 оны 8-р сар, №22 (94).
6. **Амаржаргал Д.** Чулуугаар тоглож явсан он жилүүд минь миний геологич болохын эхлэл байсан. “Геологи уул уурхайн мэдээ” сонин, 2012 оны 8-р сар, №24 (96).
7. **Энхтуяа Б.** Геологич мэргэжил гэр бүлийн минь бахархал. “Геологи уул уурхайн мэдээ” сонин, 2012 оны 9-р сар, №25 (97).